

2026 оны 09 сарын 08 өдөр

Дугаар 66.

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэг, 8.11.26 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хорооны 2026 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн хурлын тэмдэглэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэл болон Д.Хүрэлбаатарын өөрийнх нь хүсэлтийг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Худалдаа, хөгжлийн банк ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Дамбийжавын Хүрэлбаатар нь гишүүнээс чөлөөлөгдөх хүсэлт ирүүлсэн тул хүсэлтийг хүлээн авч, энэхүү тогтоол гарсан өдрөөр гишүүнээс чөлөөлсүгэй.
2. ТУЗ-ийн гишүүнийг түр орлох холбогдох хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан этгээдийг сонгон шалгаруулж, ТУЗ-ийн хуралд танилцуулах, түр томилуулахыг ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын болон нэр дэвшүүлэх хороо (Л.Нямсүрэн)-нд даалгасугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, шаардлагатай арга хэмжээг авч ажиллах, холбогдох мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



РАНДОЛФ КОППА